



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/А27

Булган сум

**“Аркфило” ХХК-тай гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2025 оны хамтын ажиллагааны гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын 4 дүгээр баг Үйлдвэр технологийн паркийн хашааны ажлын зураг төслийг Орхон сумын 4 дүгээр баг, Залуугийн булагт түүхий эдийн захын хашааны зураг төслөөр холболтын ажлыг 6,000,000 (зургаан сая) төгрөгөөр “Аркфило” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, дүрэм, журам, нормын дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Аркфило” ХХК-ийн захирал (Ц.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж, хүлээн авахыг Аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтэд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нэмэлт санхүүжилтийн харилцах данс дахь “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дэмжлэгээс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325011016